

D хавсралт

ЦДАШ-ыг шувуудад аюулгүй болгох техникийн шаардлага

ЦДАШ-ын тулгуурын бүтцийг шувуудад ээлтэй байлгах үүднээс дараах аргуудыг хэрэглэх нь зүйтэй бөгөөд тусгаарлах материал нь -50°C -аас $+70^{\circ}\text{C}$ температур болон $(6\div 15)$ кВ-ын хүчдэлийг тэсвэрлэх чадвартай, 25-35 жилийн ашиглалтын хугацаатай, 40 м/с хүртэл салхинд тэсвэртэй, хөнгөн байх шаардлагатай.


D.1 ЦДАШ-ын завсрын тулгуурын бүтцийг шувуудад ээлтэй байлгахад дараах шаардлагыг тавина

D.1.1 Тулгуурын орой дээр шувуу суух боломжийг хязгаарласан толгой эсвэл цахилгаан дамжуулдаггүй материалаар хийсэн тусгаарлагч бүрхүүл суурьлуулах

Тулгуурын оройн хэсэгт шувуу суух боломжийг хязгаарласан толгой ашигласнаар шувуу зөвхөн шаазан тусгаарлагч, эвсэл хөндлөвч дээр сууна. Тулгуурын оройд цахилгаан дамжуулдаггүй материалаар хийсэн тусгаарлагч бүрхүүл суурьлуулснаар шувууд газардуулсан биетээс бүрэн тусгаарлагдана. Тусгаарлагч материал D хавсралт-д заасан шаардлагыг хангаж байх ёстой (Зураг 1-4).

D.1.2 II болон III фазын цахилгаан дамжуулагч утсыг дүүжин тусгаарлагч ашиглан хөндлөвчийн доогуур байрлуулах


Хоёр болон гуравдугаар фазын цахилгаан дамжуулагч утсыг хөндлөвчийн доогуур байрлуулснаар (D.1-р зураг) шувууд фазын утсанд хүрэхгүй хөндлөвч дээр эрсдэлгүй суух боломж бүрдэнэ. Хоёр болон гуравдугаар фазын утас хөндлөвч төмрөөс доош 50 см-ээс багагүй зайд байх шаардлагатай.



D.1-р зураг - Тулгуурын оройд шувуу суухыг хязгаарласан толгой, болон цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч бүрхүүл суурьлуулж, II болон III фазад дүүжин тусгаарлагч ашигласан байдал

D.1.3 Дүүжин тусгаарлагч ашиглах боломжгүй үед хөндлөвчийг тусгаарлагч материалаар бүрэх эсвэл хөндлөвчийг цахилгаан дамжуулдаггүй материалаар хийх

Хөндлөвч төмрийг тусгаарлагчаар бүрэх юмуу, цахилгаан дамжуулдаггүй материалаар хийснээр шувууг газардуулгаас бүрэн тусгаарлана (D.2-р зураг). Тусгаарлагч материал нь Хавсралт D-д заасан шаардлагыг хангаж байх ёстой. Фазын утаснуудын хоорондын зай 1.5 метрээс багагүй байх шаардлагатай. Ингэснээр том биетэй шувууд 2 фазын утсанд зэрэг хүрч хүчдэлд цохиулах эрсдэл буурна.




D.2-р зураг - Тулгуурын оройд шувуу суухыг хязгаарласан толгой эсвэл цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч бүрхүүл суурьлуулж, хөндлөвчийг цахилгаан дамжуулдаггүй материалаар бүрсэн байдал

D.2 ЦДАШ-ын анкер тулгуурын бүтцийг шувуудад ээлтэй байлгахад дараах шаардлагыг тавина.

D.2.1. Тулгуурын орой дээр шувуу суух боломжийг хязгаарласан толгой эсвэл цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч бүрхүүл суурьлуулах

D.2.2. Дамжуулагч утасны холболтуудыг бүрээстэй кабелиар холбож, II, III фазын холболтыг хөндлөвчийн доогуур байрлуулах

Анкер тулгуурын оройд шувуу суухыг хязгаарласан толгой хэрэглэснээр шувууд зөвхөн оройн шаазан тусгаарлагч, эсвэл хөндлөвч дээр суух боломжтой. Харин тулгуурын оройд цахилгаан дамжуулдаггүй материалаар хийсэн тусгаарлагч бүрхүүл суурьлуулснаар шувууд газардуулсан биетээс бүрэн тусгаарлагдана. Бүх дамжуулагчийн холболтыг бүрээстэй утсаар холбож, холболтын үзүүр хэсгийг тусгаарлах материалаар бүрэх бөгөөд II болон III фазын дамжуулагчийг хөндлөвчийн доогуур байрлуулснаар шувуу хүчдэлд цохиулахаас бүрэн сэргийлнэ. Тусгаарлагч материал нь Хавсралт D-д заасан шаардлагыг хангаж байх ёстой. (D.3 зураг).



D.3-р зураг - Анкер тулгуурын оройд шувуу суухыг хязгаарласан толгой, эсвэл цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч бүрхүүл суурьлуулж, дамжуулагч утасны холболтуудыг бүрээстэй кабелиар холбож, II болон III фазын холболтыг хөндлөвчийн доогуур байрлуулсан байдал

D.2.3. Дэд станц болон тулгуурт байрлуулсан нэмэлт төхөөрөмжийн холболтонд бүрээстэй утас ашиглах

Дэд станц болон тулгуурт байрлуулсан нэмэлт төхөөрөмжүүдэд шувууд биеийн хэмжээнээс үл хамааран хүчдэлд цохиулах нь элбэг байдаг. Тиймээс дэд станцын төхөөрөмж болон тулгуурт байрлуулсан нэмэлт төхөөрөмжүүдийг бүрээстэй утсаар холбож, холболтын үзүүр хэсгийг тусгаарлах материалаар бүрснээр шувууд үүр засах, суух үед хүчдэлд цохиулах эрсдлээс сэргийлж, эрчим хүчний найдвартай байдлыг нэмэгдүүлнэ.